



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 510

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН ЦАГААН-ОВОО СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЦАГААН-ОВОО
СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА
П.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Цагаан-Овоо сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Цагаан-Овоо сумын Ардчилсан нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Цагаан-Овоо сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8: 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

"Цагаан-Овоо сумын Ардчилсан нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Цагаан-Овоо сумын Ардчилсан нам"-ын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



011020588

**ДОРНОД АЙМГИЙН ЦАГААН-ОВОО СУМЫН
АРДЧИЛСАН НАМЫН 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Тус сумын Ардчилсан намаас эхлүүлсэн ажлаа дуусгаж Иргэн бүрийг орлоготой, Өрх бүр нь өсөлттэй байлгах бодлогыг хэрэгжүүлж, Шинэ үеийн Шинэ Цагаан-Овоо сумыг цогцлоон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэв.

Мөрийн хөтөлбөрийн уриа: УНАЛТ биш ӨСӨЛТ
УХРАЛТ биш ДЭВШИЛТ

Нэг: Төрийн бодлогын хүрээнд

1.1. Төрийн бодлогын талаар

1.1.1. Мэдлэг чадвар, туршлагатай ахмад мэргэжилтэн бүхий зөвлөхүүдийн холбоог бүх салбарт байгуулж, дунд болон залуу үедээ зөвлөгөө, туршлагаасаа хуваалцах бололцоог бүрдүүлнэ.

1.1.2. Мэргэшсэн, чадварлаг албан хаагчдыг бэлтгэн нутгийн удирдлагын чадавхийг дээшлүүлнэ

1.1.3. Төрийн байгууллагын ажиллагсадыг ажиллах нөхцөл боломжоор хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод шуурхай болгох, ард иргэддээ тайлагнадаг зарчмыг хэрэгжүүлнэ

1.1.4. Төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн орчны тохижилтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байхаар тохижуулж тэднийг нийгмийн харилцаанд бусадтай адил тэгш оролцох боломжийг хангана.

1.1.5. Сумын Үйлдвэрчний эвлэлийн холбоо болон хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, зөвлөл, төрийн болон төрийн бус байгууллагыг хуулийн дагуу ажиллах нөхцөлөөр хангаж хамтран ажиллана.

1.1.6. Төрийн байгууллагын үйлчилгээний ёс зүйг сайжруулж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх арга зүйг хэвшүүлнэ.

1.2. Хуулийн хэрэгжилтийн талаар

1.2.1. Төрийн хуулийг дээдлэн, хуулийн хүрээнд ажиллах зарчмыг баримтлан, хууль тогтоомжийг иргэдэд бодлого чиглэлтэйгээр сурталчлан таниулна.

1.2.2. Гэмт хэрэг, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлж урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг татан оролцуулна.


1.2.3. Малын хулгайтай тэмцэж таслан зогсоох үр дүнтэй ажлыг зохион байгуулах, хариуцсан байцаагч ажиллуулах боломжийг эрэлхийлэх

1.2.4. Иргэдийн өргөдөл гомдол, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх арга механизмыг боловсронгуй болгох

1.2.5. Иргэдэд мэдээлэл олгох "БАГИЙН ӨДӨРЛӨГ", "ИРГЭДТЭЙ УУЛЗАХ НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ" зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

1.3. Гадаад харилцааны талаар

1.3.1. Хөрш зэргэлдээ орших ОХУ-ын Өвөрбайгалын муж, БНХАУ-ын ӨМӨЗО- Хөлөнбуйр аймагтай соёл, спорт, боловсрол, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын хүрээнд хамтарч ажиллана.



1.3.2. Улс аймагтаа ажлаараа тэргүүлсэн гадаад, дотоодын жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн хөгжлийн тэргүүний ажиллагаатай аймаг, сумын аж ахуйн нэгж, байгууллагын ажлын туршлагыг судалж сумандаа хэрэгжүүлэх бодлого барина.

1.4. Батлан хамгаалах, гамшгаас хамгаалах талаар

1.4.1. МУ-ын цэргийн шинэтгэлийн бодлого үйл ажиллагааг орон нутагт зохион хэрэгжүүлж, Цэрэг татлагын ажлыг хууль журмын хүрээнд зохион байгуулна. Иргэдийг цэргийн албыг сайн дурын үндсэн дээр

Гэрээт

Биеэр

Дүйцүүлэхээр

Мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах ажлыг зохион хэрэгжүүлнэ.

1.4.2. Гамшгаас хамгаалах багаж тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэх, засварлах

1.4.3. Иргэдэд гамшгаас хамгаалах талаар сургалт сурталчилгааг зохион байгуулах /нэмэх/

1.4.4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бодлого"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Хоёр: Нийгмийн бодлогын хүрээнд

2.1. Нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын талаар

2.1.1. Малчин өрх бүрийг нийгмийн даатгалын нэрийн данстай, Эрүүл мэндийн даатгалд хамруулах талаар арга хэмжээ авна

2.1.2. Зорилтот түвшин буюу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх халамжийн үйлчилгээг хуулийн дагуу үзүүлнэ.

2.1.3. Сумын нийт иргэдэд хэрэгцээний судалгаа хийж түүнд тулгуурласан сургалт, боловсрол, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

2.1.4. Залуу гэр бүлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана


2.2. Хөдөлмөр эрхлэлтийн талаар

2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадуудын хөдөлмөр эрхлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

2.2.2. Өрхийн бизнесийг дэмжиж бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.3. Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллагсдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгох ажлыг хуулийн дагуу хэрэгжүүлэхэд тавих хяналтыг сайжруулна.

2.2.4. "ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



2.3. Боловсролын талаар

2.3.1. Сургууль, цэцэрлэгийг интернетэд бүрэн холбож, цахим номын сан, мэдээллийн сантай болгоно.

2.3.2. Багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дотоод, гадаадын түвшинд туршлага судлах ажлыг бодлогоор дэмжинэ.

2.3.3. Сум орон нутгийн хөгжлийн суурь нь "ХҮНИЙ ХӨГЖИЛ-БИДНИЙ ИРЭЭДҮЙ" гэж үзэн иргэддээ амьдрах ухааны болон Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг сайжруулан багшлах боловсон хүчний чадварт анхаарна.

- ЕБС-ийн багшлах боловсон хүчний мэргэшлийн Заах аргач, Тэргүүлэх зэрэгтэй багшийн индексийг нэмэгдүүлэх, боловсролын магистрын зэрэгтэй багшийн индексийг нэмэгдүүлнэ.
- СӨБ-ийн багшлах боловсон хүчний мэргэшлийн Заах аргач, Тэргүүлэх зэрэгтэй багш, боловсролын магистрын зэрэгтэй багшийн тоог бодитойгоор нэмэгдүүлнэ.

2.3.4. Сургуулийн өмнөх насны бүх хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах бололцоог нэмэгдүүлэх замаар хувилбарт сургалт /хүүхэд харах үйлчилгээ, гэр цэцэрлэг гэх мэт/-ын үйл ажиллагаа, эцэг эхчүүдийн хамтын хөдөлмөр оролцоог дэмжиж ажиллана.

2.3.5. "Оюутны сургалтын дэмжлэг" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж суманд нэн шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэнэ.

2.3.6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчинг камержуулан хэвийн ажиллагааг хангах, хүүхэд хамгаалал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулж, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.3.7. МСҮТөв, Политехникийн коллежтэй хамтран мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, дадлага ажлын хүрээнд малчин иргэдийн амьдралд хүч нэмэгдүүлэх талаар хамтран ажиллах бололцоог хангаж ажиллана.

2.3.8. МСҮТ, Политехник коллежоор олгодог Өмнөх мэдлэгийг хүлээн зөвшөөрөх сургалтын хэлбэрийн хүрээнд "Мэргэжлийн үнэмлэх"-жүүлэх, "Түргэвчилсэн мэргэжил олгох хөтөлбөр"-ийг тус сургуулиудтай хамтран хэрэгжүүлнэ.

2.4. Спортын асуудлын талаар

2.4.1. Төрөл бүрийн спорт арга хэмжээг зохион байгуулж хамтран ажиллах, өсвөр үе, хүүхэд залуусыг спортоор хичээллэхэд анхаарна.

2.4.2. Ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх спортын дугуйлан, клубүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, бүх нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээнд дэмжин ажиллана.

2.4.3. Нийтийн биеийн тамир, үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх бодлого баримтална.

2.4.4. Олимпийн төрлийн спортын багш, дасгалжуулагчийг бэлтгэх ажлыг зохион байгуулна.


2.4.5. Сумаас төрж гарсан спортын алдартнуудын нэрэмжит спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулна.

2.4.6. Тэмдэглэлт баяр, ёслолт өдөрлөгийг нийтийн биеийн тамир, спортын уралдаан тэмцээн хэлбэрээр зохион байгуулж хэвшинэ.

2.5. Соёлын асуудлын талаар

2.5.1. Соёлын төвийн үйл ажиллагааг сэргээн, нийтэд хүртээмжтэй байдлаар байнгын үйл ажиллагаа зохион байгуулах боломжоор хангах

2.5.2. Орон нутгийн түүхийн болоод аялал жуулчлалын газруудын солбилцлыг тогтоож кадастрын зураг хийнэ.



2.5.3. Хэл соёл, угийн бичиг хөтлөх, уламжлалт ёс заншлаа залуу хойч үедээ өвлүүлэх зорилгоор соёлын төв, музей, сургуулийг түшиглэн төрөл бүрийн дугуйлан секц хичээлүүднэ.

2.5.4. Орон нутгийн судлах музейн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлнэ.

2.5.5. Үндэсний өв соёлоо хадгалах, уламжлах талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг дэмжинэ.

2.6. Эрүүл мэндийн талаар

2.6.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

2.6.2. Эмч, эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэх, сургах, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.6.3. Элэгний вирусийн халдвартай иргэдийн хяналт, сайн дурын дархлаажуулалтын хамрагдалтыг сайжруулснаар элэгний хавдарын өвчлөлийг бууруулна

2.6.4. Лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

2.6.5. Сумандаа нярай эхчүүд амаржих нөхцлийг сайжруулж ажиллана.

2.6.6. Сумын иргэдийн голчлон өвчилж байгаа өвчлөлийг судлах, шалтгааныг тодорхойлох, гарах үр дагаварыг буруулах арга хэмжээг авна.

Гурав: Эдийн засаг, төсөв санхүүгийн талаар

3.1. Төсөв, санхүүгийн талаар

3.1.1. Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээний хүрээ, хүртээмжийг дээшлүүлэн орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.

3.1.2. Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулна.

3.1.3. Төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалт, тендерийн ил тод байдлыг хангана.

3.2. Жижиг дунд үйлдвэрлэлийн асуудал

3.2.1. Мал аж ахуйн болон газар тариалангийн гаралтай түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг байгуулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэх

3.2.2. Малын арьс, шир элдэх түүгээр анхан шатны боловсруулалт хийх цех үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

3.2.3. Сумын ахуй үйлчилгээний төвийн үйл ажиллагааг шинээр бий болгох ажлыг судлах, эхлүүлэх.


3.2.4. Суманд талх, нарийн боов, сүү цагаан идээ, мах махан бүтээгдэхүүн боловсруулдаг жижиг үйлдвэр, цехийг зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэн оновчтой хэлбэрээр байгуулан ажиллахыг дэмжинэ.

3.3. Дэд бүтэц, бүтээн байгуулалт

3.3.1. Шилэн кабелийн сүлжээнд холбогдож айл өрх, албан байгууллагууд интернэтийн үйлчилгээгээр хангагдах боломжтой болгоно.

3.3.2. Гэр хорооллын эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх дэд станц байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.

3.3.3. Сумын төвийг хэсэгчилсэн байдлаар нэгдсэн халаалтын зуух, төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг судлах, эхлүүлэх.



- 3.3.4. Хорооллуудын гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, цамхагт гэрэл нэмж суурилуулна.
- 3.3.5. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг гаргах, нийтийн орон сууц шинээр барих, хотхон, хорооллын газрыг олгож, инженерийн шугам сүлжээг байгуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.3.6. Сумын төвийн бүхий л ундны ус худгийг цэвэршүүлэх төхөөрөмжөөр бүрэн хангана
- 3.3.7. Сумын төвийн замуудыг үе шаттай, хэсэгчилэн хатуу хучилттай зам болгоно.

Дөрөв: Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн талаар

4.1. Хог хаягдлын талаар

- 4.1.1. Сумын төвийн нэгдсэн хогийг булшлах, хашаажуулах, харгалзах манаачтай болгох, дахин боловсруулах боломжийг судлана.
- 4.1.2. Төв, суурин газрын ногоон байгууламжийг бодитоор нэмэгдүүлж, орчны тоосжилт, агаарын хуурайшилтыг бууруулна.
- 4.1.3. Хогийн цэгт хог хаях, тээвэрлэх журмыг боловсронгуй болгох

4.2. Уул уурхай, газар зохион байгуулалтын талаар

- 4.2.1. Сумын нутагт дэвсгэрт ашигт малтмалын орд ашиглалт, хайгуулын ажил хийж буй ААН, Компаниудтай хамтран ажиллах төлөвлөгөөг шинэчлэн баталж сумын Иргэдийн хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулах замаар ил тод нээлттэй ажиллана.
- 4.2.2. Хууль бусаар ан гөрөө агнах асуудалтай хатуу тэмцэнэ.
- 4.2.3. Сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг хийнэ.
- 4.2.4. Бэлчээрийн даацын судалгааг хийж, бэлчээр сэлгэлтийг оновчтой зохион байгуулна.

4.3. Бэлчээр усжуулалт, Булаг шанд, рашаан, нөхөн сэргээлтийн талаар

- 4.3.1. Сумын нутаг дэвсгэрт байгаа рашаан, булаг шандыг хамгаалах "Бэлчээр усжуулах" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.3.2. Сумын төвийн хороолол бүрт гүн өрмийн худаг гаргахыг дэмжинэ.
- 4.3.3. Хөдөөгийн багуудад гүн өрмийн болон гар худгийг малчдын оролцоотой хамтран нэмэгдүүлнэ.

4.4. Хүнсний ногоо, газар тариалан


- 4.4.1. Хадлан салаа байгуулах ажлыг нутгийн иргэдэд давуу байдлаар оролцох боломжийг бодлогоор дэмжинэ.
- 4.4.2. Өрх бүрийг хүнсний ногоо тариалахад дэмжлэг үзүүлж "Хүлэмж" хөтөлбөрийг боловсруулахаас гадна уул уурхайн компанид нийлүүлдэг иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.4.3. Орлого багатай иргэдийг малжуулах, төмс хүнсний ногоо, хадлан тэжээл бэлтгэх ажилд түлхүү дэмжлэг үзүүлнэ.

4.5. Аялал жуулчлалын талаар

- 4.5.1. Сумынхаа түүхэн дурсгалт газрыг түшиглэн аялал жуулчлал, амралт зугаалгын бүс болгон хөгжүүлэхийг дэмжинэ.

4.6. Мал аж ахуйн талаар

- 4.6.1. Мал эмнэлгийн лаборатори байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 4.6.2. Мал нядалгааны цэгийг боловсронгуй болгох ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх замаар шийдвэрлэнэ
- 4.6.3. Хувийн хэвшлийн мал эмнэлгүүдийн ажил үйлчилгээг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, малыг эрүүлжүүлэх, халдварт паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх ажлын чанар хүртээмжийг нэмэгдүүлж, эмчилгээ үйлчилгээний хөлсийг зах зээлийн ханштай уялдуулан тухай бүрт тогтооно.
- 4.6.4. Малчдын нийгмийн баталгааг хангах, залуучууд, залуу гэр бүлийг мал аж ахуйн салбарт ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.6.5. Малын удмын санг сайжруулах төсөл хөтөлбөр боловсруулж зэргэлдээ сум, аймгуудтай хээлтүүлэгчийн солилцоо хийх боломжийг бүрдүүлнэ.
- 4.6.6. Малчдын амьжиргааг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.



ЦАГААН-ОВОО СУМЫН АРДЧИЛСАН НАМ